



ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2017 оны 08-р сарын 05-ны өдөр № 214 Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нэг талаас "Улаанбаатар дулааны сүлжээ" ТЭХК-ийг төлөөлж Борлуулалт, эдийн засгийн хэлтсийн дарга М.Лууц (цаашид худалдагч тал гэх), нөгөө талаас Д.Амгийн (цаашид худалдан авагч тал гэх) нар Монгол улсын "Эрчим хүчний тухай" хууль, "Эрчим хүчний хэмнэлтийн тухай" хууль, "Иргэний хууль"-ийг үндэслэн талууд харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

1.2. Дулааны эрчим хүчийг (халаалт, орон сууцны хэрэглээний халуун ус, салхины болон технологийн халуун ус) энэхүү гэрээнд заасан тоо хэмжээнд худалдах, мөн худалдан авч хэрэглэсний төлбөрөө тогтоосон хугацаанд бүрэн төлж барагдуулах, техникийн бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааны горим шаардлагыг худалдан авагч тал ханган биелүүлэхтэй холбоотой эрх зүйн харилцааг зохицуулна.